

## **“ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ, ТӨЛБӨРТЭЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ ЖУРАМ”-ЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2017 оны 6 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 57 дугаар зүйлийн 57.8-д “Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах заавар, аргачлал болон эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийн талаархи мэдээллийг төлбөртэй авах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан тул Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах, төлбөртэй мэдээлэл авах журмын төслийг шинээр боловсруулав.

Шинээр боловсруулсан журмын төслийн зохицуулалтыг 7 зүйлтэй байхаар саналд тусгаж, шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг олж тогтоох, эрэн сурвалжлах ажиллагаанд ач холбогдол бүхий мэдээллийг төлбөртэй авах тодорхой төрлийн харилцааг уг журмаар зохицуулахаар тусгалаа.

Журмын зохицуулах харилцааг хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр ялтанг эрэн сурвалжлах ажиллагаанд хамаарахгүй байхаар зааж, төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг тогтоох чиглэлээр тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд явуулж буй ажиллагааг эрэн сурвалжлах ажиллагаанд хамааруулахаар томьёолсон.

Эрэн сурвалжлах ажиллагаанд ач холбогдол бүхий төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийн талаарх мэдээллийг гуравдагч этгээд буюу иргэнээс төлбөртэй авах нөхцөлийг тусгасан ба мэдээлэл авах нөхцөлийг дараах байдлаар журмын төсөлд санал тусгалаа. Үүнд:

- төлбөр төлөгчийн мэдээллийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хувиас доошгүй буюу 2400-72000 төгрөгөөр тооцож, иргэнээс төлбөртэй мэдээлэл авахаар;
- төлбөр төлөгчийн эд хөрөнгийн талаар эрэн сурвалжлах ажиллагаанд ач холбогдол бүхий мэдээллийг мэдээлэгч иргэнтэй харилцан тохиролцсон хэмжээгээр тооцохоор зааж, харилцан тохиролцох үнийн дүнгийн дээд хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байхаар тусгасан. Төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зардлыг хуульд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд хамруулахаар заасныг үндэслэн нарийвчилсан зохицуулалтыг журамд тусгасан.

Мөн журмын төсөлд эрэн сурвалжлах шийдвэр гаргах, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах нөхцөл, олж тогтоосон төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийн мэдээллийг харилцан солилцох, төлбөр төлөгчийг шийдвэр гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх, батлан даалт тогтоох, батлан даагчид хүлээлгэх хариуцлага, эрэн сурвалжлах ажиллагааг дуусгавар болгох нөхцөлийг зохицуулахаар журмын төсөлд тусгалаа.

Журмын төслийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран боловсруулсан болно.

**БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗАР**